“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ “ШИЖИР-АЛТ” АЛТНЫ ҮЙЛДВЭР

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ УРТ САЙР АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/ АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: **MV-022475**/

/ АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: **2550466** /

2026 ОН

ГАРЧИГ

ОРШИЛ

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1.Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл

1.2 Төслийн байршил

1.3 Ил уурхайн хүчин чадал, ашиглалтын технологи

1.3.1. Хүчин чадал

1.3.2 Төслийн ашиглалтын технологи

1.4 Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл

1.5 Ил уурхайн ажиллах горим, ашиглах хугацаа, цалингийн сан, ажиллах бүтэц

1.5.1 Ил уурхайн ажиллах горим

1.6 Орд нээх ба ашиглах тооцоо

1.7 Уурхайн дэд бүтэц

1.7.1 Цахилгаан хангамж

1.7.2 Усан хангамж

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АРАВ. БОМТ-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

АРВАН НЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

АРВАН ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

АРВАН ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

ОРШИЛ

Зорилго: “МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ын алтны уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зорилго оршино.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ын алтны шороон ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, химийн хортой болон аюултай бодисын эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын ба газрын доорх усны нөөц, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий,ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ) нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газрын ажлын хэсгийн дүгнэлт, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудтай тайлагнах үйл ажилллагаа зэрэг ажлууд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт багтсан.

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд 40,4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг зардлын хамт тусгав.

Агаарын чанар хөрсөн бүрхэвч, гүний усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох.

Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох,

Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

1.1 Төслийн танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл, бичиг баримтын бүрдэл

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.11	Төсөл хэрэгжүүлэгч: Төслийн нэр:	“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ MV-022475 тоот тусгай зөвшөөрөлтэй “Урт сайр” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
1.2	РД:	РД: 2550466
1.3	УБДугаар:	УБД: 9013001062
1.4	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 98 өрийн байр. Утас: 99985355 Захиралын үүрэг гүйцэтгэгч: Д.Мөнхсайхан Утас: 99114622
1.5	Хог хаягдлын гэрээ	Сумын Байгаль орчны улсын байцаагчтай байгуулна.
1.6	Тусгай зөвшөөрөл:	АМГТХЭГ-ын даргын 2007 оны 07-р сарын 04-ны өдрийн шийдвэрээр 15 жилийн хугацаатай олгосон байна
1.7	Археологийн дүгнэлт:	Археологийн хүрээлэнгийн 2020 оны 05 сарын 21-ны өдрийн тайлан, дүгнэлт
1.8	Ус ашиглуулах дүгнэлт Ус ашиглах гэрээ	2025 онд үйл ажиллагаа явуулаагүй байгаа
1.9	Хаягдал усны дүгнэлт	2025 онд үйл ажиллагаа явуулаагүй байгаа
1.10	Урт нэртэй хуулийн лавлагаа	Давхцалгүй.
1.12	Нөөц хүлээн авсан тушаал, тэмдэглэл дүгнэлт	Үндэсний геологийн албаны 2022 оны 06 сарын 22-ны өдрийн №Н-55 тоот бүхий нөөц тодотгол хүлээн авсан тушаал Уул уурхай хүнд үйлдвэр яамны АМГТГ-ын нөөц тодотгол хүлээн авсан 2022 оны 01 сарын 20-ны өдрийн № ХХ-01-08 тоот тэмдэглэл дүгнэлт
1.13	ТЭЗҮ хүлээж авсан дүгнэлт	Уул уурхай хүнд үйлдвэр яамны АМГТГ-ын нөөц тодотгол хүлээн авсан 2022 оны 12 сарын 22-ны өдрийн №22-12-08 тоот тэмдэглэл дүгнэлт
1.14	Байгаль орчны аудит хийлгэсэн эсэх	2023 онд “Эковишн” Байгаль орчны аудитын мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэсэн байна. Аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж байна.

Commented [ba1]: Үүний он нэр олох

1.15	Ус ашиглах зөвшөөрөл, эрхийн бичиг, дүгнэлт	2026 оны уулын ажлын төлөвлөгөөг батлуулсан бөгөөд ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, дүгнэлтийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.
1.16	Хаягдал усны дүгнэлт, төлбөр төлөх гэрээ	2025 онд үйл ажиллагаа явуулаагүй болно.
1.17	ГТБЧУХБ дүгнэлт	2023 онд “Говь-Эко” ХХК-иар хийлгэж Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2017 оны 12 сарын21-ны өдрийн №1/2435 тоот Улсын ерөнхий шинжээчийн баталгаажсан дүгнэлт
1.18	Худгийн паспорт	Төв аймгийн байгаль орчны албаны даргын 2011 оны 05 сарын 29ны тушаалаар батласан.
1.19		
1.20	Усны тайлан	
1.21	Ерөнхий үнэлгээний дүгнэлт	БОАЖЯ-ны 2023 оны 02 сарын 27-ны өдрийн №12/1039 тоот
1.22	Дүйцүүлэн хамгаалах ажил хийсэн мэдээлэл	Төв аймгийн БОАЖГазраас орон нутгийн талбайд оноож өгсөн газарт дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлтийн ажлыг үйлдвэрийн хэмжээнд гүйцэтгэнэ.
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	“Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Урт сайр нэртэй газарт хэрэгжиж буй MV-022475 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий ордыг ил аргаар ашиглах” төсөл
2.2	Төслийн байршил	Газрын байршил орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс Заамар сумаас 29 км 2017 оны 5 дугаар сарын 12-нд батлагдсан “Хог хаягдлын тухай хууль” –ийн 25.1 дэх шаардлага болон “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105 : 2001 стандартын шаардлагыг хангаж байна.
2.3	Төслийн зорилго	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаас гарсан шийдвэрийг танилцуулах үеэрээ “Алт-III” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ" хэмээн мэдээллээ. Дэлхийн зах зээл дээр нэг унц алт 3000 ам.доллар давсан байгаа энэ үед алтны олборлолтыг нэмэгдүүлэх нь зүйтэй юм. Иймээс Алт-III” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлээд буй. Алтны олборлолтыг нэмэгдүүлснээр алтны болон валютын улсын нөөцийг бүрдүүлэх тал дээр чухал дэмжлэг болно. Иймд төслийн хувьд улсын бодлогын чанартай буюу Валютын нөөцийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр болох зорилготой юм.
2.4	Төслийн талбайн байршил	Газрын байршил орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 0.8 км-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105 : 2001 стандартын шаардлага хангаж байна.
2.5	Төслийн хүчин чадал	Ил уурхайн хүчин чадал: Экскавтороор жилд 10.64 мян.тн

Commented [ba2]: Хаана хэнээр хийлгэсэн

		Ил уурхайн ашиглалтын жил: 1 жил
2.6	Төслийн хог хаягдал	Хатуу хог хаягдал: Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор хоногт 59.34 кг, жилд 12.7 тн орчим хаягдал гарах бөгөөд харъяа дүүргийнхээ холбогдох /ТҮК/-тэй байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэдэг байна. Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана. Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна. Шингэн хог хаягдал: Нийт 33 ажилтантай гэж үзвэл хоногт 5,52 м3, жилд амралт баяр ёслолын өдрийн хасаад 180 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 1181.8 м3/жил болно. Сууринд цэвэршүүлэх төвлөрсөн байгууламжтай. Хийн хаягдал: Уурхайн хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд бол автомашины утаа байна. Уурхайн ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт 335.6 тн дизель түлш зарцуулахад –15.28тн, CO-0.00096 тн, нүүрстөрөгч–0.000382 тн, NO2–0.0000471 тн, SO2-0.00001743тн, бензопирин-0.0003127 тн буюу нийтдээ 15.28 тн хорт хий ялгарахаар байна.
1		

1.2 Төслийн байршил

MV-022475 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос баруун хойш 200 км, Төв аймгийн Заамар сумын төвөөс баруун тийш 40 км зайд байрлана. Нийт 144,83 га талбай хэмжээтэй.


MV-022475 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн солбицол


№	Уртраг	Өргөрөг
1	104° 36' 00"	48° 26' 52"
2	104° 33' 55.56"	48° 26' 52"
3	104° 33' 55.62"	48° 26' 43.89"
4	104° 34' 2.93"	48° 26' 43.89"
5	104° 34' 3.02"	48° 26' 33"

6	104° 36' 00"	48° 26' 33"


Газрын байршил орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 0.8 км-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105 : 2001 стандартын шаардлага хангаж байна.

Зураг 1. Төслийн талбайн сансрын зураг урт сайр





Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг



Зураг 3 . Урт сайр алтны шороон ордын нөөцийн дэвсгэр зураг

ИЛ УУРХАЙ

Урт сайр нэртэй алтны шороон ордыг ашиглах техник-эдийн засгийн үндсэлэлийг ЭБМЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн ХХ-17-03 тоот дүгнэлтээр Урт сайр нэртэй алтны шороон ордын нөөцийг С зэргээр 28.83 кг-р /х.ц/ хүлээн авч Монгол улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн нөөцөд тулгуурлан боловсруулав. Техник эдийн засгийн үндэслэлийг ордын нөөц болох 14.4 кг-р /х.ц/ алт буюу 438 мг/м3 алтны агуулгатай 35.48 мян.м3 элсийг олборлохоор боловсруулаа.

ОРДЫН УУЛ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

“Урт сайр” нэртэй 144.83 га бүхий MV-022475 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбайд явуулсан өмнөх геологийн судалгааны үед тус орд нь үйлдвэрлэлийн үр ашигтай нөөц бүхий гурван давхаргатай бөгөөд ордын дээд давхаргын хөрсний дундаж зузаан нь 4.6 м, элсний зузаан 0.8 м, дунд давхаргын хөрсний дундаж зузаан нь 15.7 м, элсний зузаан 1.2 м, доод давхаргын хөрсний дундаж зузаан нь 46.9 м, элсний зузаан 1.1 м ордын хөрс хуулалтын итгэлцүүр 10.01 тус тус байна.

Талбайд явуулсан өмнөх геологийн судалгааны үед цэвдэг илрээгүй ба харин хүйтний улиралд хөрсний хөлдөлт 2.5-3.0 м хүрдэг болох нь тогтоогдсон. Ордыг ашиглах үед уул геологи, гидрогеологийн талаас ямар нэг хүндрэл байхгүй. Орд нь уул техникийн нөхцөлийн хувьд хүндрэлгүй, тээвэртэй ашиглалтын систем ашиглан ил аргаар олборлолт явуулах бололцоотой гэж үзэж байна

- Хөрсний эзлэхүүн жин- 1.7 тн/м^3
- Элсний эзлэхүүн жин- 1.7 тн/м^3
  Хөрсний чулуулгийн бат бэхийн коэффициент Профессор М.М.Продотъяконовын ангиллаар f =1-2 (зөөлөндүү ба зөөлөн чулуулаг) байна.

АШИГЛАЛТЫН СИСТЕМИЙН СОНГОЛТ

Ашигт малтмалыг аюулгүй, эдийн засгийн үр ашигтай, иж бүрнээр ашиглах, нөөцийг бүрэн гүйцэт авах, байгаль орчинд сөрөг нөлөө бага байх зэрэг нөхцөлөөс хамааранашиглалтын системийг сонгох нь үндсэн нөхцөл болно. Урт сайр алтны шороон орд нь харьцангуй бага уналтай, 3 давхаргаас бүрдэх ба хучаас хөрс, ашигт давхаргын зузаан, алтны агуулга хувирамтгай үзүүлэлттэй, тууз хэлбэрийн энгийн

тогтоцтой, III бүлгийн жижиг хэмжээний ордод хамаарна.Шинээр нээх блокуудыг эхлээд бульдозероор шимт хөрсийг хуулан салхины нөмөр газар сонгосон талбайд тусад нь овоолго үүсгэж, хучаас хөрсийг экскаватор- автосамосвалын хослолоор хуулан уурхайн баруун хойд талд байрлах хөрсний овоолгод овоолон, нээгдсэн блокийн тухайн хэсгийн элсийг олборлон, тодорхой орон зай гарсны дараа дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлтийн ажлыг уулын ажилтай зэрэг явуулахаар төлөвлөв.

Уурхайн ашиглалтын технологи

Технологи	Үндсэн ажил	Технологийн процесс
Авто тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	· Ухаж ачих
		· Тээвэрлэх
		· Овоолох
	Элс олборлолт	· Ухаж ачих
		· Тээвэрлэх
		· Овоолох

Ил уурхайн хажуугийн тогтворжилт, ашиглалтын системийн элементүүд

Ил уурхайн хажуу ба доголуудын налуугийн өнцгийн баримжаа хэмжээ(“Гипроруда”-гийн баримтлал)

Чулуулгийн бат бөхийн тодорхойлолт	Чулуулгийн бат бөхийн коэффициент (проф. М.М.Протодьяконовын шаталбар)	Ил уурхайн доголын налуугийн өнцөг, град	Ил уурхайн гүнээс хамаарах хажуугийн налуугийн өнцөг, град			
			90	180	240	300
Дээд зэргийн бат бөх ба маш бөх чулуулаг	15-20	75-85	60-68	57-65	53-60	48-54
Бөх ба бөхдүү чулуулаг	8-14	65-75	50-60	48-57	45-53	42-48
Дунд зэрэг бөх чулуулаг	3-7	55-65	43-50	41-48	39-45	36-43
Зөөлөндүү ба зөөлөн чулуулаг	**1-2**	**40-55**	**30-43**	28-41	26-39	24-36
Зөөлөн ба шороо	0.6-0.8	25-40	21-30	20-28	-	-

Ашиглалтын системийн элементүүд. Экскаватор, автосамосвалын техникийн үзүүлэлтүүд болон ордын хөрсний чулуулгийн физик, механикийн шинж чанар, олборлолтын нөхцөл, ашигт давхарга, хөрсний зузаан зэргээс хамааруулан ашиглалтын системийн үндсэн хэмжигдэхүүнүүдийг аргачлалын дагуу тооцоолж доорх хүснэгтэд ***Доголын өндөр:*** Захиалагч компанийн эзэмшлийн техникүүдээс сонгосон экскаваторын утгалтын гүн, бага гүний ордын хөрсний зузаан зэргээс хамааруулан хөрсний ажлын доголын өндрийг дунджаар Нд=3.5 м байхаар тооцов.

Доголын хажуугийн өнцөг: Доголын хажуугийн өнцөг нь чулуулгийн шинж чанарын нөхцөлөөр ажлын доголд αд=55^0, ажлын бус доголд αд=50^0 байна. Энэхүү хэмжээ төсөл зохиомжид мөрдлөг болгодог нөхцөлтэй зөрчилдөхгүй (f=1-2, зөөлөндүү ба зөөлөн чулуулаг бол αд=40^0-55^0).

Ажлын талбайн өргөн: Ажлын талбай нь тухайн догол бүрд хэрэгжүүлэх технологийн процессуудыг явуулах орон зайн нөхцөлийг хангахад зориулагдана. Тээврийн аюулгүй зай, техникийн ажиллах нөхцөл, нурлын өргөн зэргийг тооцож үзэхэд ажлын талбайн хамгийн бага өргөн 35-40 м байна.

Ил уурхайн үндсэн хэмжээсүүд

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Тоо, хэмжээ
1	Доголын өндөр - Хаалтын догол - Хөрсний догол - Элсний догол /давхаргын зузаанаар/	м	 - 7 -3.5 0.4-1.6
2	Доголын хажуугийн өнцөг - Ажлын догол - Ажлын бус - Ил уурхайн ерөнхий налуу	градус	 - 55 - 50 -40-45
3	Экскаваторын орлын өргөн	м	12
4	Аюулгүйн бермийн өргөн	м	2.5

5	Ажлын талбайн өргөн	м	36
6	Траншейн замын өргөн	м	12
7	Траншейн замын налуу	‰	80

Уурхайн төлөвлөлтийн ерөнхий шийдлүүд:

- Уулын ажлыг зураг төсөлд төлөвлөсний дагуу явуулах бөгөөд уурхайн ажиллах хүч, үндсэн болон туслах техник тоног төхөөрөмж, уурхайн хотхон, дэд бүтцийн объектууд, бэлтгэл ажил бүрэн хангагдсан байна.
- Ашиглалтын эхнээс хөрсний дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлтийг уулынажилтай хамт явуулахаар төлөвлөсөн бөгөөд энэ нь нөхөн сэргээлтийн ажлыг хөнгөвчлөх, зардал хэмнэх, богино хугацаанд ордыг унаган төрхөд нь ойртуулах зэрэг таатай нөлөөтэй байна.

Ил уурхай:

144,83 га тусгай зөвшөөрлийн талбайн 30 га-д үйл ажиллагаа явуулна. Уурхай нь өмнө нь олборлолтонд өртөж байсан талбай болно. Төлөвлгөөт онд нийт 68.03мян.м3 хөрс хуулж, 10.61 мян.м3 элс олборлоно.

Хөрс хуулалт:

Төслийн хугацаанд экскеватороор 128 мян.м3 инженерийн ажил хийж гүйцэтгэх бол, бульдозероор 18.4мян.м3 хөрс хуулалт, шилжүүлэлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Уурхайн технологийн зам:

Уурхайн технологийн зам нь замын хөдөлгөөн, аюулгүй ажиллагааны шаардлагуудын дагуу тэмдэг, тэмдэглэгээтэй байна. Уурхайн технологийн зам нь одоогийн байдлаар 3.9 км урт 10 м өргөн байгаа бөгөөд уурхайн эцсийн жилийн байдлаар нийт 5 км урт, 10 м өргөн технологийн замтай байхаар төлөвлөсөн.

Скрубберээр угаан баяжуулах хэсэг:

СКБ-80 скруббер, YGL60A маркын шлюз, булинга дамжуулах хоолой, К-320, К-400, К-700 маркын усны насосууд, СКМ-1А маркын баяжуулах ширээ, торон шигшүүр зэрэг тоног төхөөрөмжүүдээс бүрдэх бөгөөд уурхайн төлөвлөлт болон скрубберээр баяжуулах элсний байршлаас хамаарч төсөл үргэлжлэх хугацаанд 3 удаа скрубберийн байршлыг солихоор төсөлд тусгасан.

Хаягдлын овоолго:

Скрубберээс нийт 10 мян.м3 хаягдал гарах бөгөөд 1 хэсэг газарт хаягдлын овоолгыг үүсгэхээр төлөвлөсөн бөгөөд жил бүрийн төлөвлөлтийн зурагт үзүүллээ.

Хөрс хуулалтын коэффициент:

Уурхайн хувьд хөрс хуулалт бага ба нийт 3 блокуудад хөрс хуулалтын ажил хийгдэнэ. Ордын хэмжээнд хөрс хуулалтын дундаж 3.1 /м3 байна.

Догол, уурхайн хажуу:

Уулын ажлын ухалт, ачилтыг 3.0 м3 утгууртай Doosan DX-520 загварын экскаваторуудаар хийж гүйцэтгэнэ. Ил уурхайн хамгийн их гүн 9 м тул DX-520 экскаваторааp 65°-ийн налуутай 4-5 м өндөр 1 догол дээр олборлолтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Уурхайн ахилт:

Уулын ажлын ахилт нь төлөвлөгөөт онд С-7-8-с эхлэн С-4 гэсэн блокуудад ахилттай байна.

1.7 Уурхайн дэд бүтэц

1.7.1 Цахилгаан хангамж

Уурхайн цахилгааны эх үүсвэрийг Дархан-Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээний харьяа “Жаргалант” салбарын “Баясгалант” 110/35/10кВ-ын дэд станцаас цахилгаан хангамжийг авахаар төсөлд тусгасан.

1.7.2 Усан хангамж

Урт сайрын алтны уурхай нь 4-н үндсэн усны хэрэглээтэй. Үүнд:

Унд-ахуйн ус хэрэглээ, Ил уурхайн зам талбайн усалгаа, Биологийн нөхөн сэргээлтэд зарцуулах ус, Технологийн ус

Тус төслийн ашиглалтын технологи угаах төхөөрөмж, гүн, нам дүүргэлтийн шлюз, тунаах машин, баяжуулах ширээний дамжлагаар угаан баяжуулна.

Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процесс
Экскеватор	Хөрс хуулалт	- Ухах
		- Шидэх (Гадаад ба дотоод овоолго)
Скруббер	Элс олборлолт	- Ухах
		- Угаах үйлдвэр

Уурхайн үйлдвэрлэл технологийн хэрэгцээний тогтоол усаас/хангах бол унд ахуйн хэрэглээний усыг Хайлааст багийн төвөөс зөөвөрлөнө.

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашигладаг. Битүү эргэлтийн системээр усыг ашиглахад хаягдлын болоод цэвэр усны санг байгуулсан.

1) Ундны болон ахуйн усан хангамж, усны хэрэглээ

Ахуйн хэрэглээний усны тооцоо: Уурхайд нийт 32 хүн ажиллана. Нэг хүний ус хэрэглээний норм хоногт ажлын болоод ахуйн хэрэгцээнд дунджаар 80л орчим байна. Уурхайн ахуйн усыг худгаас зөөж хангана. (* - БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт – “Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр – 80л/хоног/хүн)

2) Зам талбайн усны хэрэглээ

БОАЖНХЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалаар батлагдсан ус хэрэглээний нормын дагуу 1 м2 зам талбайг 2.0 л усаар усална гэсэн нормоор усны хэрэгцээг тодорхойлбол. Уурхайн дотоод тээврийн зам 39000 м2, өдөрт 1 удаа жилийн 125 хоногт /1 жил дэхь ажиллах хоног/ усална гэж тооцлоо.

Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 4 цаг тутамд явуулна (зөвхөн өдрийн цагаар). Автоцистерн тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замд хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Тоос дарах ажлыг тоноглосон нэг усалгааны машин гүйцэтгэнэ.

3) Биологийн нөхөн сэргээлтийн усны хэрэглээ

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбайд MNS:5917-2008, MNS:5918-2023 стандартуудын дагуу нөхөн сэргээлт хийнэ. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төлөвлөгөөт онд үйлдвэрийн хэмжээнд 2500 ширхэг мод тарина.

Нөхөн сэргээлтэнд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 11-р хавсралтын дагуу 2 настай навчит модыг 40 л/мод нормоор, олон наст ургамлаар нөхөн сэргээсэн талбайг 4 л/м2 нормоор услахаар тооцлоо. Усалгааг жилд 40 хоног хийнэ.

4) Үйлдвэрийн усан хангамж

Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж эргүүлэн ашиглах бөгөөд технологийн усны 81,8 %-ийг эргүүлэн ашиглахаар төсөлд тусгасан. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 43.1 мян.м3 жил ус хэрэглэхээр төсөлд тусгасан.

Скруберт нуруулдан уусгах баяжуулах технологийн зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 2-р хавсралтын дагуу алтыг нуруулдан уусгах 0.8 м3/тн нормоор ус ашиглахаар тооцоолов.

Баяжуулах үйлдвэрт шаардагдах усны 20%-ийг цэвэр усаар сэлбэх ба 80%-ийг технологийн эргэлтийн усаар хангах юм. Технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэнэ.

Эргэлтийн усан хангамжийн байгууламж

Усан сан. Битүү эргэлтийн системээр усыг ашиглахад хаягдлын болоод цэвэр усны санг байгуулсан. Усан сангийн багтаамж нь ажлын 5 хоногийн нөөцийг хангахад хүрэлцээтэй байна.

Технологийн усан хангамжийн үйл ажиллагаа нь тунгаагуур бүхий усан сан-уст давхаргаас шүүрсэн ус хуримтлуулах усан сан –ус шахах насос –угаах төхөөрөмж гэсэн схемээр явагдана.

5) Нийт усны хэрэглээ

Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдал

Оршин суугчид нөлөөллийн бүсийн дотор талд хаваржаа, өвөлжөө байрлахгүй учир газар ашиглалтын эрх зөрчигдөхгүй.

Төсөл хэрэгжсэнээр ажлын байр бий болж, нутгийн иргэд ажилд орно.

Төсөл хэрэгжих хугацаанд 2.5-3.5 сая төгрөгийн дундаж цалинтай нийт 32 хүн шууд хэлбэрээр ажлын байраар хангагдах бол 1.27 тэрбум төгрөгийн худалдан авалт, ажил үйлчилгээтэй холбоотой 100 орчим хүний ажлын байранд шууд бишээр нөлөөлнө.

Түүх соёлын дурсгалт зүйлс, тусгай хамгаалалттай газар нутаг

Судалгааны талбайн хэмжээнд эртний амьтан ургамлын үлдвэр илрээгүй байна.

Цаашид тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд ашиглалт явуулах үе шатанд палеонтологийн сонирхолтой үнэт ховор олдвор илэрсэн тохиолдолд олборлолтын ажлыг түр зогсоож холбогдох байгууллагуудад хандан авран хамгаалах ажил хийгдэнэ.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Зардал мян.төг (Эхний жил)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Бүтээн байгуулалтын өргөтөлийн үе шатанд	Агаарын чанар	Машин техникийн хөдөлгөөнөөс ихээхэн хэмжээний тоосжилт үүсэх Бүтээн байгуулалтын үед дуу шуугианы бохирдол үүсэх	Бүтээн байгуулалтын ажилд оролцох техникийн хэрэгслийг нэгдсэн замаар зорчуулах Шөнийн цагаар их хэмжээний дуу чимээ гаргахгүй байх, ажилчдын байрыг дуу чимээ тусгаарлагч бүхий материалаар барих	Уурхайн ашиглалтын талбайд	Урсгал зардлаар	Жил бүр	MNS 4597:2013
	Хөрсөн бүрхэвч	Бүтээн байгуулалтын үйл ажиллаагаар хөрс эвдрэх, цөлжилт болох эх үндэс бий болох Хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрс хамгаалах төлөвлөгөө боловсруулах, шимт хөрсийг хадгалах Хог хаягдлыг зориулалтын саванд ангилж хийх	Уурхайн ашиглалтын талбайд	1 000.0	Төслийн хугацаанд	MNS 5916 : 2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Зардал мян.төг (Эхний жил)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Ургамлан нөмрөг	Машин техникийн хөдөлгөөн, газар шорооны ажил, барилга барих талбайн ургамлан нөмрөг бүрэн устах	Машин техникийн хөдөлгөөний хурд хязгаарлах	Уурхайн ашиглалтын талбайд	Урсгал зардлаар	Төслийн хугацаанд	MNS 4597:2013
	Амьтны аймаг	Бүтээн байгуулалтын өргөтгөл үйл ажиллагаа, ажилчдын нөлөө, чимээ шуугиан нөлөөгөөр зэрлэг амьтад дайжих	Шөнийн цагаар гэрэл болон дуу шуугианы бохирдол үүсгэхгүй байх	Уурхайн ашиглалтын талбайд	Урсгал зардлаар	Төслийн хугацаанд	-

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Зардал мян.төг (Эхний жил)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үйл ажиллагааны үе шатанд	Агаарын чанар	Ордыг ил аргаар олборлох үйл ажиллагааны үед тоосжилт бий болох Уурхайн үйл ажиллагаанд оролцох машин техникээс хорт агууламж бүхий утаа ялгарах	Зам талбай, овоолго, тоос босох гадаргууг хөрс барьцалдуулагч шингэнээр нягтаршуулах, тусгай материал тороор хучих, ургамалжуулах зэргээр тоосжилт бууруулах арга хэмжээ авах	Уурхайн ашиглалтын талбайд	6 000.0	Төслийн хугацаанд	-
	Гүний ус	Алт олборлох талбай болон ажилчдын хотхон нь усыг төлөвлөгөөний дагуу бус хэтрүүлэн хэрэглэснээс гүний усны нөөц хомсдох Шатах тослох материалыг алдснаар хөрсийг бохирдуулснаас газрын доорхи ус бохирдох	Усыг дахин ашиглах, хуримтлуулах Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах	Зориулалтын хадгалх сав	1 900.0	Жил бүр	Усны тухай хууль MNS 2662-2002

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Зардал мян.төг (Эхний жил)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Хөрсөн бүрхэвч	Шатах тослох материал асгарах, гэнэтийн болзошгүй аваар осолоос үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах Шимт хөрсний овоолго үүсгэсний дараа хөрс сийрэгжсэн байх тул хөрс салхинд хийсэх,үерийн усанд урсан магадлалтай	Хөрсөн бүрхэвчийг талхагдахаас сэргийлж олон салаа зам үүсгэхгүй байх, нэгдсэн замын хөдөлгөөний сүлжээ зураг самбар тавих ШТС агуулахын урьд хайрга дайрга асгаж хөрсөн бүрхэвчийг хамгаалах, хатуу хучилттай болгох.	Уурхайн талбайд	4 000,0	Жил бүр сэргээх	MNS “5917:2008”
	Ургамлан нөмрөг	Уурхайн үйл ажиллагаанаас ургамалан бүрхэвч доройтох	Нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгэх, Жил бүр ургамлын судалгаа мониторинг явуулах, нөхөн сэргээлт хийхэд тохиромжтой үрийг орон нутгаас худалдан авах, үрийг түүх	Уурхайн талбайд	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан	Төслийн хугацаанд	MNS 5918:2023

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Зардал мян.төг (Эхний жил)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Амьтны аймаг	Уурхайн ухаш болон уурхайн талбайд зэрлэг амьтад нэвтрэх, улмаар нүх рүү унаж гэмтэх, хог хаягдлаас хордох Нөхөн сэргээлтийг журмын дагуу хийгээгүйгээс амьдрах орчин доройтох Уурхайн ажилчид хууль бусаар амьтан агнах үйлдэл гаргах	Уурхайн овоолго болон ухашын гадуур хамгаалах шуудуу, хайс, тор татах Ажилчдын тосгонд галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэглэхийг хориглох	Уурхайн талбай	Урсгал зардлаар	Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль
Нийт					11 900.0		

нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Урт сайр”-ын алтны шороон ордын уурхайн орчмын газрын хэвлий, газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

Дараах хууль дүрмийг баримтлан хэрэгжүүлнэ. Үүнд:

MNS5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт,

MNS5917:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт

MNS5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах биологийн нөхөн сэргээлт

Тус ордыг ашиглах төслийн Уулын ажлын 2026 оны төлөвлөгөөнд, 3 га талбайд техникийн нөхөн сэргээлт, үүнээс 2 га талбайд биологийн нөхөн сэргээлт талбайд дүйцүүлэн хамгаалах чиглэлээр 2 га техникийн нөхөн сэргээлт /орон нутгийн Байгаль орчны газартай хамтран/ ажиллах хийхээр тусгасан.

Хүснэгт 17. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн чиглэл	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Техникийн нөхөн сэргээлт, уурхайн хаалт	12,1 га талбай хамарна	га	12,1		162,752.12	2026- оны 09-10 сард	Өмнөх ашиглалтын үед эвдэрсэн талбайг нөхөн сэргээх ба 2027 онд төлөвлөлт хийгдэж дахин ажиллах болно
	Тэрбум мод тарих	Төслийн талбайд салхин доод талд модоор хашлага хийх	ширхэг	5,000	10,000	50,000,0	2026 оны намрын тариалалт	MNS 6774 : 2019
	Биологийн нөхөн сэргээлт-шимт хөрс болон биологи	Эвдэрсэн газар бүхий 2 га талбайг шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийнэ.	га	2		19,250,0	2026 оны 6 сар	MNS 5918: 2023 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
	Нийт					232,002.12		

ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Урт сайр”-ын алтны шороон ордын уурхайд 2026 онд дараах дүйцүүлэн хамгаалах ажлууд хийгдэнэ. Үүнд:

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсны дагуу орон нутгийн тусгай хэрэглээний 2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, орон нутагт хүлээлгэн өгнө.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
Хүснэгт-18

Дүйцүүлэн хамгааллын стратеги	Гүйцэтгэх ажил	2026 он
Нөхөн сэргээлт 2024 аян	Орон нутгийн өгсөн чиглэлийн дагуу нөхөн сэргээлт хийх	Орон нутгийн эзэмшлийн 2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ 15 000,0
	Нийт мян.төг	15 000,0

ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Урт сайр”-ын алтны шороон ордын талбайн ойр орчим нөлөөллийн бүст айлын өвөлжөө, хаваржаа бүхий газартай давхцаагүй учир нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох ажил хийгдэхгүй.

ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус ордын талбайд одоогоор энэ төрлийн олдвор олдоогүй. Хэрэв уурхайн эдэлбэр газрын хүрээнд түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентологийн олдвор илэрсэн тохиолдолд сум, аймгийн захиргаанд болон мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж, зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулна.

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тусгалаа.

Хүснэгт-19 Осол, эрсдэлийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Зардал /мян.төг/ 2026 он	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг баримт
	1	2	3	4	5	6	
1	Болзошгүй аюул осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж	Дотоод төлөвлөлтөөр		Байнга	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2012.05.17/ Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги Уул уурхайн ангиар “Аваар устгах төлөвлгөө” батлуулан мөрдөн ажиллана.
		Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчдад	15 200,0	15 200,0	Жилд 1 удаа	
		Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Ажилчдын хотхон, ил уурхайн ажлын байранд		Дотоод төлөвлөлтөөр	Үйл ажиллагааны туршид	
2	Байгалийн гэнэтийн аюулт үзэгдэл	Уурхайн эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах	Үерийн уснаас хамгаалах далан байгуулах		Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөнд орсон.		
Нийт					15 200,0		

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хатуу хог хаягдал

Уурхайн барилгын ажил болон олборлолтын ажилд хэрэглээд илүү гарсан машин, техникийн сэлбэг, эд ангийн баглаа боодол, машины дугуй, сольсон хуучин сэлбэг, замын тэмдэглэгээ, тэдгээрийн холбогдох хэрэгсэл, эрэг боолт зэрэг хаягдлууд бий болно.Уурхайн ажилчдаас ундааны сав, лааз, цаас, нийлэг эд материалууд, хөвөн даавуу болон малын яс гэх мэт хүмүүсийн эдэлж хэрэглэсэн янз бүрийн ахуйн хэрэглээний хог хаягдал гарна.

Уурхайн барилгын ажил болон олборлолтын үед ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжүүдэд зохих хуваарийн дагуу техникийн үйлчилгээ хийх үед ажилласан тос, тосолгооны хаягдал материал гарахаар байна.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө Хүснэгт-20

№	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Зардал /мян.төг/ 2026 онд	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Хог хаягдлаас үүсэх орчны бохирдол	Ахуйн хог хаягдлаа орон нутгийн ЗДТГ-тай хог хаягдлын гэрээ байгуулан тээвэрлүүлэх		Дотоод төлөвлөлтөөр	Долоо хоногийн 1 дэхь өдөр болгон	Хог хаягдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/
		Ахуйн хатуу хог хаягдал хаях сав байрлуулах	4 000,0	4 000,0	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
		Аюултай хог хаягдлыг хүлээн авах хуулийн этгээдтэй гэрээ байгуулан, тээвэрлэн хүргэх	1 020,0	1 020,0	Жил бүр	
		Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашаа барих, тэмдэгжүүлэх	5 000,0	5 000,0	Уурхайн ажил эхлэхийн өмнө	
Нийт				10 020,0		

АРАВ. БОМТ-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Урт сайр”-ын алтны шороон ордын үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Удирдлага,зохион байгуулалтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

-Байгаль орчны талаар таниулах том хэмжээтэй мэдээллийн самбар байршуулах
-Саарал усыг эргүүлэн ашиглах төлөвлөгөө боловсруулж багийн мод усалгаанд ашиглах
-Лицензийн талбайд үүссэн өндөр овоолгыг намсгах, цөөрмыг дарах ажлыг зохион байгуулж дарах
Багийн удирдлагаар зөвшилцөн багийн төвийн замуудыг цэвэрлэх байгууламжийн хаягдал усаар усалгаа хийх, модыг услах арга хэмжээг зохион байгуулна.

АРВАН НЭГ. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн лабораториор байгаль орчны хяналт шинжилгээг хийлгэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр Хүснэгт-22

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг	Зардал /мян.төг/ 2026 он	Баримтлах стандарт ба аргачлал	Дээд доод хязгаар
Агаарын орчин								
	TSP	Мкгр/м3	Уурхай, ажилчдын байр орчим, хог хаягдлын цэг	Жилд 2 удаа	Агаарын орчны хэмжилт хийлгэх агаарын үзүүлэлтүүд	1 300,0	MNS17.2.316-88 суурин газрын агаарын чанарыг хангах MNS 3384:82 агаар мандлын сорьц авахад тавигдах ерөнхий шаардлага MNS5585:2008 агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ техникийн шаардлага	дундаж – 100, жилийн дундаж- 300
	PM10	Мкгр/м3						
	PM2.5	Мкгр/м3						дундаж – 50, жилийн дундаж- 25
	NO2 / азотын давхар ирсэл	Мкгр/м3						20 минутын дундаж 200
	SO2/ хүхэрлэг хий	Мкгр/м3						20 минутын дундаж 450
	Дуу чимээ		Уурхай орчмоос		Шинжээчийн зардал	1 300,0		16 цагийн дундаж 60, 8 цагийн дундаж 50
Хөрсөн бүрхэвч								
	Механик бүрэлдэхүүн	%	Техноген нөлөөлөлд өртөөгүй хяналтын цэгт Ажилчдын суурин орчимд	Жилд 1 удаа 3 цэгт	Хөрсний химийн шинжилгээ, хүнд металлын шинжилгээ Эрүүл ахуй	1 300,0		Хэмжилтээр
	Ялзмагт үеийн зузаан	см						Хэмжилтээр
	Ялзмаг	%						Хэмжилтээр
	карбонат	%						21

	Хүнд элементийн агууламж	Мг/100гр	Уурхайн үйлдвэрийн орчимд					1,8
	Бусад бохирдлын үзүүлэлтүүд	Мг/100гр						хэмжилтээр
Усан орчин								
	Усны бохирдлын шинжилгээ		Туул голын ус эргэлтийн усан сан Технологийн ус Ундны ус	Жилд 2 удаа, 4цэг	Усны ерөнхий шинжилгээ Хүнд металын шинжилгээ	1 280,0	-MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус – Химийн шинжилгээ хийх- дээж авах, хадгалах, зөөвөрлөх, - MNS /ISO/ 566711:2000 Усны чанар, дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж - MNS 900:2009, Хүний унд ахуйн зориулалттай усны чанарын норм, - MNS 6148 – 2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
5180,0								

АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа алтны шороон ордын сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах, санал бодлыг тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм.

БОМТ-ний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт-23

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
	Төв аймаг, Заамар сумын “Хайлааст” багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	ИНХ товлосон хугацаанд 2026 оны 10 дугаар сард	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	Төв аймаг, Заамар сумын “Хайлааст” багийн ИНХ
	БОАЖЯ-ны ХБОБНУГ	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар		БОУАӨЯ-нд
	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн дүгнэлт	12-р сар	Цаашид анхаарах асуудал	Заамар сумын ЗДТГ-т

АРВАН ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

БОМТ-ний нийт зардал

Хүснэгт-24

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал /төгрөг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11,900,000
2	Нөхөн сэргээлт, уурхайн хаалтын зардал	232,002,120
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Дотоод төлөвлөлтөөр
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Дотоод төлөвлөлтөөр
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15,200,000
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	10,020,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Дотоод төлөвлөлтөөр
9	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	Дотоод төлөвлөлтөөр
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	5,180,000
	Нийт	289,302,120

АРВАН ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

“Урт сайр” алтны шороон ордыг ашиглах төслийн 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, байгаль орчны төлөв байдалд хяналт шинжилгээ хийх зорилгоор боловсруулав.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

Сөрөг нөлөөллийг бууруулах: Уул уурхайн үйл ажиллагаанаас хөрс, ургамлан нөмрөг, агаар болон усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, тоосжилтоос урьдчилан сэргийлэх, тээврийн хэрэгслийг тогтоосон зам, маршрутаар зорчуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Нөхөн сэргээлт, ойжуулалт 2026 онд 3.57 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 2 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. Мөн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 5000 мод тарих, тарьсан модны ургалт, амьдрах чадварыг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.


Байгаль орчны хяналт-шинжилгээ: Агаар, хөрс, усны чанарт хяналт-шинжилгээ хийлгэж, шинжилгээний үр дүнгээр байгаль орчны төлөв байдалд үнэлгээ өгч, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хог хаягдлын менежмент, эрсдэлээс урьдчилан сэргийлэх: Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, зайлуулах ажлыг холбогдох шаардлагын дагуу зохион байгуулж, болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 289,302,120 (хоёр зуун наян есөн сая гурван зуун хоёр мянга нэг зуун хорин) төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Уг зардалд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалал, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлын менежмент, байгаль орчны хяналт-шинжилгээ хаалтын зардлыг тусгасан болно.

ХАВСРАЛТ


Техникийн нөхөн болон биологийн нөхөн сэргээлт хийх талбайн зураг



Блокууд болон техник биологийн нөхөн сэргээлт мэдээлэл координат

2026 онд олборлолт явуулах талбайн байршил								
№	Метрийн		Солбилцол					
	градус	минут	Өргөрөг			Уртраг		
1	470159	5365851	48	26	37.806	104	35	45.107
2	470364	5365802	48	26	37.806	104	35	45.107
3	470334	5365610	48	26	39.228	104	35	59.64
4	470155	5365858	48	26	35.977	104	35	55.604
2026 онд техникийн нөхөн сэргээлт хийдэх талбай байршил								
1	468802	5366146	48	26	37.801	104	35	45.107
2	468878	5366108	48	26	37.806	104	35	45.107
3	468858	5365947	48	26	39.228	104	35	59.64
4	468780	5366002	48	26	35.977	104	35	55.604
5	468537	5365981	48	26	35.988	104	35	55.604
6	468533	5366041	48	35	21.034	104	17	56.004
7	468650	5366073	48	35	21.044	104	17	14.438
8	468771	5366068	48	35	21.019	104	17	13.718
Биологийн нөхөн сэргээлт хийгдэх талбай солбилцол								
1	468537	5365981	48	26	35.988	104	35	55.604
2	468533	5366041	48	35	21.034	104	17	56.004
3	468650	5366073	48	35	21.044	104	17	14.438
4	468771	5366068	48	35	21.019	104	17	13.718

Биологийн нөхөн сэргээлт хийх талбайн зураг зураг



Тэрбум мод тарих талбайн байршлын зураг оруулах

